

# “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 4-ний өдөр

№ 21/36

Улаанбаатар хот

## Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнийг түр орлох этгээд томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.5, 77.6 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5, 9.11 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн Үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.11 дэх хэсэг, Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 2021 оны 9 сарын 30-ны өдрийн ЗХ-21/03 тоот дүгнэлт, Компанийн ТУЗ-ийн 10 сарын 04-ний өдрийн ээлжит бус хурлын эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 2021 оны 9 сарын 30-ны өдрийн ЗХ-21/03 тоот дүгнэлтийг үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл хугацаанд өөрийн хүсэлтээр чөлөөгдсөн Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлох этгээдээр Монгол Улсын иргэн Даваасамбуу овогтой Галхүүг томилсугай.
2. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.6 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлохоор томилогдсон Монгол Улсын иргэн Даваасамбуу овогтой Галхүү нь Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүний эрхийг 2021 оны 10 сарын 04-ний өдрөөс эхлэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл хугацаанд эдлэхийг дурдсугай.
3. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлохоор томилогдсон Монгол Улсын иргэн Даваасамбуу овогтой Галхүүд Монгол Улсын хууль тогтоомж, Компанийн дүрэм, Компанийн ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам болон компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
4. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлох этгээд томилогдсон тухай мэдээллийг холбогдох журамд заасны дагуу олон нийгэд мэдээлж ажиллахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д үүрэг болгосугай.



# **“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2021 оны 10 сарын 04-ний өдөр

№ 21/37

Улаанбаатар хот

## **Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйл, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн Үйл ажиллагааны журмын 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Компанийн ТУЗ-ийн 2021 оны 10 сарын 04-ний өдрийн ээлжит бус хурлын эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай. Үүнд:

а. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдлийн удирдлагын хороо:

Хорооны дарга: Б.Дэлгэржаргал;  
Гишүүд: О.Болдбаатар;  
С.Энх-Амгалан;  
В.Баярсайхан;  
Н.Цэвэгмид;  
Д.Галхүү.

б. ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин, урамшууллын хороо:

Хорооны дарга: С.Энх-Амгалан;  
Гишүүд: С.Боргил;  
Д.Галхүү.

2. Монгол Улсын Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжууд, Компанийн дүрэм, Компанийн ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам, Компанийн холбогдох бусад журмыг мөрдөж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбоотой мэдээллийг холбогдох журамд заасны дагуу олон нийтэд мэдээлж ажиллахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д үүрэг болгосугай.

